



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Баянтээг

Г Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүү, хөрөнгө оруулалтын тайлан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай Г

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, тооллогын комиссын дүнг үндэслэн “Баянтээг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Баянтээг” ХК-ийн 2022 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангалттай гэж үзсүгэй.
2. Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа хангалтгүй байгааг засах, сайжруулах чиглэлээр холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Төлөөлөн Удирдах зөвлөлөөр шуурхай шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ:  /Ч.ГҮНСЭНХОРОЛ/





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 02

Баянтээг

2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн  
Аудитын байгууллагын тайлан дүгнэлтийг  
хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа  
эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” ХК-ийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Өвөрхангай аймгийн  
Төрийн аудитын газрын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 152 дугаар дүгнэлтийг  
хүлээн авч баталсугай.
2. Аудитын хязгаарлалттай дүгнэлтэд дурдсан зөрчил, үүссэн үр дагаварыг арилгах  
талаар холбогдох шийдвэр гаргаж хэрэгжүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх  
захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



*[Handwritten signature]*



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 03

Баянтээг

Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 18/04 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт 1-ээр болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хавсралт 2-оор баталсугай.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д үүрэг болгосугай.
3. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 18/04 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор нүүрс экспортын гэрээг байгуулж хэрэгжүүлэх, үүнээс шалтгаалан компанийн үйл ажиллагааг өргөтгөхтэй холбоотой хийх өөрчлөлтүүдийг дээрх төлөвлөгөөнд оруулах асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр тухай бүр нь шийдвэрлүүлж хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-т үүрэг болгосугай.
4. Төлөвлөгөөнд тусгагдсан “Баянтээг” ХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг нэмэгдүүлэх зорилгоор тус уурхай орчмын газрыг аймгийн тусгай хэрэгцээнд авах асуудлыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг)-д даалгасугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



/Ч.ГҮНСЭНХОРОЛ/



Хувьцаа эзэмшигчийн хурлын  
2023 оны 7 сарын 19 өдрийн 08 тоот  
тогтоолын 1-р хавсралт

д/д	Зардлын төрөл	Тоо	Бараа ажил	Төсөв	Зориулалт	Тайлбар
1	Нүүрсний нөөцийн чанарын судалгаа хайгуулын зардал	1	ажил	2,495,000.0	Нүүрсний нөөц өсгөх, чанар тодорхойлох	Хийгдэж байгаа
2	Зам усалгааны машин	1	бараа	80,000.0	Технологийн зам	Нээлттэй
3	HYUNDAI 520 Соёо	1	бараа	15,500.0	Хатуу хөрс суллах	Шууд
4	ИТА-н автомашин L-200	1	бараа	23,000.0	Ажилчдын	Харьцуулалтын
5	Уурхайн бүст 4 жи сүлжээний өргөтгөл	1	ажил	30,000.0	Хөрс хуулах/ хуучин/	Нээлттэй
6	GPS хяналтын систем	21	ажил	10,000.0	Шатахуун зарцуулалтыг хянах	Шууд
7	Радио долгионы станц	20	бараа	20,000.0	Ажлын харилцаа холбоо	Шууд
8	Карьерт ажлын оффис /Зөөврийн сууц /	1	бараа	25,000.0	ИТА-н ажлын байр	Харьцуулалт
9	Борлуулалт, бүртгэлийн хэсэг шинээр барих	1	ажил	100,000.0	Байгууллагын үйл ажиллагаанд	Нээлттэй
10	Карьерт засварын газар барих	1	Бараа	64,000.0	Байнгын дулаан гараж	Харьцуулалт
11	Сэлбэгийн агуулах барих	1	ажил	51,000.0	Байгууллагын үйл ажиллагаанд	Харьцуулалт
12	Худаг гаргах, засварлах	1	ажил	25,000.0	Байгууллагын үйл ажиллагаанд	Шууд
13	Тог баригч	4	Бараа	10,000.0	Байгууллагын үйл ажиллагаанд	Шууд
14	Санхүүгийн программ		ажил	10,000.0	Байгууллагын үйл ажиллагаанд	Шууд
	<b>НИЙТ ДҮН</b>			<b>2,958,500.0</b>		



Хувьцаа эзэмшигчийн хурлын  
2023 оны 04 сарын 29 өдрийн 05 тоот  
тогтоолын 2-р хавсралт

д/д	Үзүүлэлт	2022 оны төлөвлөлт	2022 оны гүйцэтгэл	2023 оны төлөвлөлт
	<b>Нүүрс тн</b>	<b>230000</b>	<b>254860.15</b>	<b>230000</b>
1	Нүүрс борлуулалт	7945453.5	8804259.7	10350000.0
2	Тээврийн орлого	25000.0	10573.5	25000.0
3	Дулаан борлуулалт	38000.0	33829.7	35000.0
4	Бусад орлого	10000.0	2850.9	10000.0
5	Борлуулалтын буцаалт	-2500	0	-2500
	<b>Цэвэр борлуулалт, орлогын дүн</b>	<b>8015953.5</b>	<b>8851513.8</b>	<b>10417500.0</b>
1	Үндсэн болон нэмэгдэл цалин	1328735.3	1307547.1	1848910.6
2	ЭМД,НД шимтгэл	192666.7	185839.5	268092.0
3	Бичиг хэрэг	4735.5	7302.4	6155.5
4	Албан томилолт	13567.0	12906.1	33650.0
5	Гадаад томилолт			30000.0
6	Шатах тослох материал	1565379.0	1388055.9	1784020.0
7	Сэлбэг	203854.0	166979.2	235895.0
8	Шуудан холбоо	19500.0	17805.2	18840.0
9	Хэвлэл захиалга	2000.0	792.0	2000.0
10	ТУЗ-ийн зардал	33682.2	25806.7	40731.0
11	Хөдөлмөр хамгаалал	106501.5	49801.1	135387.0
12	Шагнал урамшуулал	10000.0	10650.5	10000.0
13	Тэтгэмж тусламж	125000.0	118584.5	125000.0
14	Тэсэлгээний материал	214299.5	53104.6	90942.5
15	Байгаль орчныг хамгаалах	86877.6	36878.6	66877.6
16	Элэгдэлийн зардал	580000	656038.2	650000.0
17	Зар сургалчилгааны зардал	5000.0	11200.0	10000.0
18	Сургалтын зардал	10000.0	14310.0	10000.0
19	Татвар төлбөр хураамж	1167751.0	861941.5	1600167.6
20	Түлшний хөнгөлөлт	14782.0	12323.4	24795.0
21	Гэрэл цахилгаан	154627.5	157680.3	168928.0
22	Ажилчдын хоолны зардал	45360.0	68349.5	60480.0
23	Урсгал засвар	170000.0	117808.6	169200.0
24	Их засвар	373800.0	357845.5	257454.0
25	Бусдаар гүйцэтгүүлэх ажил	280000.0	282272.1	40000.0
26	Актласан хөрөнгийн зардал	15000.0	4469.4	15000.0
27	Уралдаан тэмцээн	10000.0	8800.0	10000.0
28	Дотоод нүүрс	46683.0	32957.4	55282.5
29	Арга хэмжээний зардал	77000.0	112371.8	57489.1
30	Харуул хамгаалалтын зардал	15000.0	5500.0	15000.0
31	Нийгмийн өмнө хүлээх хариуцлага	191000.0	209634.6	250000.0
32	Нөгдол ашиг	25260.8	25260.8	252608.0
33	1 тэрбум модны хөтөлбөр	49000.0	40500.0	10000.0
34	Бусад	20000.0	20443.8	20000.0
	<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>7,157,062.6</b>	<b>6,381,760.3</b>	<b>8,372,905.4</b>
	<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>788,390.9</b>	<b>2,422,499.4</b>	<b>2,044,594.6</b>
	1 тн нүүрсний өөрийн өртөг нийт зардлаар	31117	25040.2	36400



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 04

Баянтээг

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон  
Хараат бус гишүүдийг томилох

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

1. Ч.Гүнсэнхорол
2. Б.Ичинноров
3. М.Нинжбадгар
4. О.Батсүрэн
5. Ю.Батсайхан
6. Д.Миезгомбо

2. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

1. З.Дашзэвэг
2. Ц.Оюун
3. Н.Болдбаатар нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.



ХУРАЛ ДАРГАЛАГЧ

/Ч.ГҮНСЭНХОРОЛ/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 05

Баянтээг

Г Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах  
журам батлах тухай Г

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, тооллогын комиссын дүнг үндэслэн “Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмыг хавсралт 3-аар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах зөвлөлийн Даргад үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



/Ч.ГҮНСЭНХОРОЛ/



## БАЯНТЭЭГ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн бүрэн эрх, түүний гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага болон хурал зохион байгуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь хуулийн хүрээнд, компанийн дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах, ТУЗ-ийн хурлыг бэлтгэж зохион байгуулах, Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан асуудлыг хэлэлцэн зохих шийдвэр гаргах, биелэлтэд хяналт тавих, гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдүүлэх, тэдгээрт цалин, хөлс олгох, ажлыг нь дүгнэх, хариуцлага хүлээлгэх зэрэгт энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.3. Шинээр гарсан хууль, тогтоомж болон удирдах дээд байгууллагын тогтоол, шийдвэр, компанийн дүрэмд орсон өөрчлөлт зэрэгт нийцүүлэн энэ журамд зохих нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулж байна.

### ХОЁР. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭН ЭРХ

2.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн тухай хууль болон компанийн дүрмийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлаас бусад компанийн гүйцэтгэх удирдлагад хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.2.1. Компанийн жилийн санхүү, бизнес төлөвлөгөө гэх мэт компанийн стратеги, бизнесийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;

2.2.2. Бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалт хийх, үндсэн хөрөнгө данснаас хасах;

2.2.3. Эзэмшигчийн өмчийн өөрчлөлтийг тооллого, тооцоо, санхүүгийн баримтад тусгаж байгаа эсэх;

2.2.4. Гадаад томилолтын удирдамж, төсөв, гүйцэтгэлд хяналт тавих;

2.2.5. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийж, тусгай шалгалт явуулах хүсэлт гаргах;

2.2.6. Компанийн нөөц хөрөнгө болон бусад мөнгөн хөрөнгийг ашиглах асуудлыг шийдвэрлэх;

2.2.7. Хуульд заасан тохиолдолд их хэмжээний хэлцэл болон бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй тусгай хэлцлийг хэлэлцэн батлах;



2.2.8. Нийт гишүүд нь тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй байх, эсвэл тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүд дотор нь хараат бус гишүүд байхгүй, бусад тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах эсэхийг шийдэх;

2.2.9. Гишүүд компанийн гүйцэтгэх удирдлага, компанийн бүтцийн нэгжийн дарга нараас өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл авах;

2.2.10. Гүйцэтгэх удирдлагын багийн хурлын тэмдэглэлтэй танилцах хүсэлт тавих;

2.2.11. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын санал болгосноор ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх;

2.2.12. ТУЗ-ийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэгдээгүй асуудлуудыг гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багт шилжүүлэхгүй;

2.2.13. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулна.

### ГУРАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

3.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна.

3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурлыг сард нэг удаа хуралдуулна. Хурал хуралдуулах газар, огноог ТУЗ-ийн дарга товлож, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /цаашид “нарийн бичгийн дарга” гэх/ бэлтгэлийг хангана. Зарласан ээлжит хурлыг урьдчилан тохиролцож хойшлуулж болно.

3.3. Шаардлагатай гэж үзвэл тухайн сард нэмэлт хуралдааныг ТУЗ-ийн дарга, гишүүн, Компанийн гүйцэтгэх захирлын санаачлага, шаардлагаар хуралдуулж болно. Хурлыг санаачлагч нь нарийн бичгийн даргатай хамтран хурлын бэлтгэлийг хангана.

ТУЗ-ийн дарга хурал зарлахаас үндэслэлгүйгээр татгалзсан эсвэл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй бол, ТУЗ-ийн бусад гишүүн тус хурлыг зарлаж болно.

3.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд саналаа эцнээ өгч, ажлын журмаар шийдвэр гаргаж болно. Энэ тохиолдолд нарийн бичгийн дарга ТУЗ-ийн даргын зөвшөөрлөөр гишүүдээс санал авч дүнг гаргах бөгөөд ТУЗ-өөс гарах шийдвэрт гишүүн бүрийн өгсөн саналыг хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд тэмдэглэнэ.

3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /цаашид “хурал” гэх/-аар ТУЗ-ийн даргын баталж, урьдчилан тараасан материал, танилцуулга, шийдвэрийн төсөлтэй асуудлыг (Дөрөвдүгээр хавсралт) хэлэлцэнэ.

3.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг компанийн тухайн ажил хариуцсан (бичиг хэрэг) албан тушаалтан ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай хамтран /зөвлөлдөн/ бэлтгэж, холбогдох материал /судалгаа, тооцоо, гэрээ, хэлэлцээр, түүний биелэлт болон бусад зүйл/-ыг хавсаргах бөгөөд компанийн гүйцэтгэх захирал, холбогдох албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Хурлаар хэлэлцэхээр төлөвлөсөн асуудал бүр танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй байна.

ТУЗ-ийн хуралд Гүйцэтгэх удирдлагын зүгээс оруулж ирж байгаа материал нь компанийн үйл ажиллагаанд тулгарч байгаа үндсэн асуудал, учрах гол эрсдэлүүд

болон түүнийг бууруулах арга хэмжээ, холбогдох арга хэмжээг аваагүй тохиолдолд үүсэх үр дагавар, хохирлыг хамарсан дүгнэлт, тооцоо судалгааг багтаасан байна.

3.7.Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг Хурал хуралдах өдрөөс 2-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүргэсэн байна. Компанийн бизнесийн нууцтай холбоотой тооцоо судалгаа болон хувилж олшруулахад техник ажиллагаа ихээхэн шаардагдах материалыг гишүүд компани дээр урьдчилан ирж танилцан, саналаа бэлтгэж болно.

3.8.Гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

3.9.Хурлыг ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх захирлын саналаар өргөтгөн хийж болно.

3.10.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ. ТУЗ-ийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн хурлаас шийдвэрлэсэн аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

3.11.Хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүн тус бүр саналын нэг эрхтэй байна. ТУЗ-ийн нэг гишүүний саналын эрхийг нөгөө гишүүнд шилжүүлэх, саналын эрхийг өөр хүнд итгэмжлэлээр дамжуулахыг зөвшөөрөхгүй. Хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Эхний санал хураалтаар шийдвэр хүчин төгөлдөр болж чадаагүй нөхцөлд уг асуудлыг дахин нягтлан хэлэлцэж, зөвшилцөх замаар дахин санал хурааж болно. Гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд дахин санал хураана.

3.12.Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийн хэлбэр нь тогтоол, хурлын тэмдэглэл байна. Тогтоолыг ТУЗ-ийн албан бланк (Нэгдүгээр хавсралт) дээр хэвлэн, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн ТУЗ-ийн тэмдэг дарна.

3.13.Компанийн болон ТУЗ-ийн дотоод асуудалтай холбоотой, түүнчлэн тухайн хурал дээр шийдвэрлэх боломжгүй, тодруулах, судлах шаардлагатай асуудал гарвал ТУЗ-ийн хурлаас “ТУЗ-ын хурлын тэмдэглэлээс” гэсэн хэлбэртэй (Хоёрдугаар хавсралт ) шийдвэр гаргаж болно.

3.14.Хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг (Гуравдугаар хавсралт) ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хөтлөх ба санал хураалтын дүнг гишүүдийн нэрээр гаргаж тэмдэглэнэ. Дэлгэрэнгүй тэмдэглэлийг аудио, видео техник ашиглан хийж болно. ТУЗ-ийн дарга хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлтэй танилцаж, гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

ТУЗ-ийн хурлын тэмдэглэл дээр тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцсан ТУЗ-ийн дарга, хуралд оролцсон нийт гишүүд, компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

3.15.Хурлаар асуудал хэлэлцэхдээ дараах дэгийг баримтлана:

3.15.1.Хэлэлцэх асуудлыг компанийн гүйцэтгэх захирал (асуудлыг хариуцан боловсруулсан бол ТУЗ-ийн гишүүн), эсхүл компанийн тухайн асуудлыг хариуцсан ТУЗ-ийн гишүүн, эрхэлсэн албан тушаалтан танилцуулна.

3.15.2. ТУЗ-ийн гишүүд асуулт асууж танилцана;

3.15.3. ТУЗ-ийн гишүүд санал гаргана;

3.15.4. Хурал даргалагч ТУЗ-ийн гишүүдийн саналд үндэслэн ТУЗ-өөс гаргах шийдвэрийн төслийг томъёолно;

3.15.5. Санал хурааж, ТУЗ-өөс гарах шийдвэрийн төслийг баталгаажуулна.

3.16. Хурлаас гарсан шийдвэрийн нэг хувийг компанийн захиргаанд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хүлээлгэн өгнө. Шаардлагатай гэж үзвэл хурлын шийдвэрийг нийт ажилтнуудад танилцуулж болно.

3.17. Гишүүд хуралд биеэр болон цахим хэлбэрээр оролцох үүрэгтэй.

3.18. Хэрэв санал хураалтыг энгийн хэлбэрээр явуулах бол "дэмжих", "эсэргүүцэх", "түдгэлзэх" гэсэн сонголтын аль нэгээр асуудал бүрээр санал өгөх;

3.19. Дараах шийдвэрүүдийг гаргахад хуралд оролцож чадахгүй хүмүүсээс бичгээр санал хураахгүй. Үүнд:

Компанийн бизнесийн чиглэл, санхүү болон бизнесийн төлөвлөгөө батлах;

Компанийн жилийн тайланг урьдчилсан байдлаар батлах;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах эсвэл зарлахаас татгалзах;

ТУЗ-ийн даргыг сонгох, чөлөөлөх;

Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг түр хугацаагаар түдгэлзүүлэх, өөрчлөх, томилох, албан тушаалаас нь чөлөөлөх;

Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах талаар ХЭХ-д зөвлөмж өгөх;

Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг хэлэлцэн батлах,

3.20. Хурлын зарлал хүлээн авсан боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралд оролцоогүй гишүүнийг тасалсанд тооцох ба эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлсний 30 хүртэл хувийг ТУЗ-ийн даргын шийдвэрээр хасаж болно.

3.21. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ТУЗ-ийн хуралд 3, ба түүнээс дээш удаа, эсвэл тухайн жилд хийсэн хурлын 50 хувьд биеэр оролцоогүй гишүүнийг Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасны дагуу төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийн төрийг төлөөлөх эрхийг дуусгавар болгоно.

3.22. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд биеэр хүрэлцэн ирэх боломжгүй гишүүн хурлаар хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцах, саналыг

дугуйнд хийн битүүмжилж ТУЗ-ийн даргад хүргүүлнэ. Энэ тохиолдолд түүнийг хуралд биеэр оролцсонд тооцно.

3.23.Хурлын ирцийг нарийн бичгийн дарга бүртгэнэ. ТУЗ-д ажилласан бүртгэлийг үндэслэн эрх бүхий байгууллагаас тогтоосон цалин хөлс олгох тодорхойлолтыг 2 хувь гарган ТУЗ-ийн даргаар батлуулах бөгөөд энэ нь цалин хөлс олгох шийдвэр болж, 1 хувь нь компанийн санхүүгийн баримтад, 1 хувь нь ТУЗ-ийн бичиг хэрэгт хавсрагдана.

3.24.Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлыг компанийн жил бүрийн төсөвт тусган эрх бүхий байгууллагаар батлуулна.

### **ДӨРӨВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО**

4.1.Төлөөлөн удирдах зөвлөл нь тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороод байгуулна.

4.2.Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байна.

4.3.Хороодын гуравны хоёроос доошгүй нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

4.4.Хороод нь шинжээч, мэргэжилтнүүд авч ажиллуулж болох ба тэдгээрийн ажлын хөлсийг тодорхойлно.

4.5.Хорооны хурлыг хорооны дарга, хорооны гишүүн, мөн компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хуралдуулна.

4.6.Асуудал хэлэлцэх хорооны хэлэлцүүлгийн дүнг хуралд оролцсон бүх гишүүдийн гарын үсэг зурж бичгээр гаргасан шийдвэрт тусгаж, ТУЗ-ийн даргад танилцуулна.

4.7.Хорооны гаргасан саналуудыг зөвлөмж гэж авч үзнэ.

4.8.Хороодын ажиллах журмыг ТУЗ батална.

### **ТАВ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

5.1.Гишүүд эрх, үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ:

5.1.1.Шийдвэр гаргахдаа ул суурьтай, үнэнч шударга хандаж, компани болон хувьцаа эзэмшигчдийн язгуур эрх ашгийн төлөө ажиллана. Өөрөөр хэлбэл бүх боломжит мэдээллийг анхаарч үзэх, ойролцоо нөхцөл байдалд анхааралтай хандаж, сайтар бодож боловсруулсан шийдвэр гаргах;

5.1.2.Зарлагдсан хурлуудад оролцох, сонгогдсон ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажилд оролцох;

5.1.3.Тодорхой бус, ойлгомжгүй асуудлуудын талаар тодруулга хийж, асуулт тавих;

5.1.4.ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд оролцох боломжгүй шалтгаанаа ТУЗ-д урьдчилан мэдэгдэж, бичгээр саналаа өгнө.

5.2.ТУЗ-ийн гишүүн нь холбогдох хууль, журмыг мөрдлөг болгон ажиллана:

5.2.1.Гишүүнээр ажиллаж буй компани болон түүний салбар компанийн үнэт цаастай холбоотой үйл ажиллагаанд оролцох зорилго гэх мэт компанийн үйл ажиллагаа, гэрээ, төсөлд хувийн арилжаа, ашиг сонирхлын улмаас (шууд болон шууд бус) оролцох бол энэ талаар ТУЗ-ийн даргад нэн даруй бичгээр мэдэгдэх ба үнэт цаастай холбоотой үйл ажиллагааныхаа талаар мэдээлнэ;

5.2.2.ТУЗ-ийн гишүүний хувьд албан тушаалын эрх мэдлийнхээ хүрээнд гаргасан шийдвэр, үйл ажиллагааны шагнал, эсхүл шагналд тооцогдохоор ямар нэгэн бэлэг, үйлчилгээ, эсхүл мөнгөн орлогыг хувь хүн, аж ахуйн нэгжээс авахгүй, албан ёсны үйл ажиллагааны үеэр ерөнхий зөвшөөрөгдсөн эелдэг зан чанарын хэм хэмжээний дагуу талархсанаа илэрхийлнэ;

5.2.3.ТУЗ-ийн гишүүнээр ажиллах үедээ олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөгдсөний дараа гурван (3) жилийн турш дээрх мэдээллийг ашиглах ёсгүй хүмүүст задруулахгүй, хувийн ашиг сонирхол болон гуравдагч талын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх;

5.2.4.Компанийн нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах дотоод журмаар тогтоосон дүрэм, журмын дагуу ажиллах.

5.3.Хараат бус гишүүд хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Хэрэв нөхцөл байдалд өөрчлөлт орсны улмаас хараат бус гишүүн хараат бус байх боломжгүй болсон бол тухайн гишүүн энэ талаар ТУЗ-д бичгээр мэдэгдэнэ.

5.4.ТУЗ-д компанийн бизнес болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн тухайн асуудлыг эрхэлсэн албан тушаалтан өгнө.

5.5.Энэхүү журмын 5.2-т заасны дагуу гишүүд өөрсдийн гаргасан алдаа, албан үүргээ биелүүлээгүйгээс үүдэн компанид учирсан хохиролд хариуцлага хүлээнэ.

5.6.Компанид алдагдал учруулах шийдвэрийн эсрэг санал гаргасан, эсхүл санал хураалтад оролцоогүй гишүүд учирсан хохиролд хариуцлага хүлээхгүй.

5.7.Энэхүү журмын 5.2-ыг зөрчиж шийдвэр гаргасан гишүүд хамтдаа хариуцлага хүлээх ба хохирлыг хувь тэнцүүлэн нөхөн төлнө.

**ЗУРГАА.ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД**

## ОЛГОХ ЦАЛИН, ГИШҮҮДИЙН АЖЛЫГ ҮНЭЛЭХ

6.1.ТУЗ-ийн гишүүд Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэгт заасны дагуу цалин, хөлс авна.

6.2.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрт үндэслэн гишүүдэд ТУЗ, ТУЗ-ийн хороодын гишүүний үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардлын нөхөн төлбөр, мөн ажлын хөлсийг ажиллах хугацаанд нь олгоно.

6.2.1.Гишүүдийн урамшуулал хөлс;

6.2.2.Жилийн үндсэн цалин хөлс;

6.3.3.Хуралд оролцсоны тогтмол цалин урамшуулал;

6.3.4.ТУЗ-ийн хороодод ажиллах гэх мэт нэмэлт ажил үүрэг гүйцэтгэхэд олгох нэмэлт цалин хөлс;

6.3.5.ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн аль нэг хорооны даргаар ажиллах гэх мэт нэмэлт хариуцлага хүлээхэд олгох нэмэлт цалин хөлс.

## ДОЛОО. БУСАД

7.1.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу үүрэг хүлээнэ.

7.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлд заасны дагуу үүрэг хүлээнэ.

7.3.Нарийн бичгийн дарга нь компанийн ажилтнуудаас ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, ТУЗ-ийн даргад танилцуулан хариу өгч байна.

7.4.Нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн шийдвэрийн биелэлтийг улирал бүр гаргаж, ТУЗ-ийн хуралд танилцуулж байна.

7.5.Нарийн бичгийн дарга нь ТУЗ-өөс компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний биелэлтийг бүтэн жилээр гүйцэтгэх захирлаар гаргуулж, ТУЗ-ийн хуралд танилцуулж байна.

7.6.ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хурал дууссанаас хойш долоон хоногийн дотор үйлдэж, ТУЗ-ын дарга, хуралд оролцсон гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

7.7.Гишүүдийн бичгээр гаргасан саналыг хурлын тэмдэглэлд хавсаргана.

7.8.ТУЗ нь хэлэлцэх асуудлын төлөвлөгөө гарган батлуулна. (Тавдугаар хавсралт)

7.9.ТУЗ-ийн дарга шаардлагатай гэж үзвэл компанийн бизнес төлөвлөгөө батлах, төсөл хэрэгжүүлэх, зээл авах, үндсэн хөрөнгө авах, данснаас хасах, хөрөнгө оруулалт хийх, охин компани, салбар, нэгж байгуулах зэрэг ихээхэн хэмжээний хөрөнгө зарцуулахтай холбогдсон асуудал, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийг хурлаар хэлэлцэхдээ ажлын хэсэг байгуулан нарийвчлан судалж, санал, дүгнэлт гаргасны үндсэн дээр шийдвэр гаргаж болно. Мөн төлөөлөн

удирдах зөвлөл нь компанийн менежмент, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой үүрэгтэй ажлын хэсэг байгуулж, ажил үүргийг нь тогтоон өгч ажиллуулж болно.

7.10. Төлөөлөн удирдах зөвлөл нь батлагдсан зардлын төсвийг зориулалтын дагуу зарцуулах бөгөөд тайланг нарийн бичгийн дарга хагас, бүтэн жилээр гарган ТУЗ-ийн хуралд танилцуулж байна.

7.11. Төлөөлөн удирдах зөвлөл нь гишүүдэд тодорхой хариуцах ажил, үүргийн хувиар гарган өгч, компанийн аппаратын үйл ажиллагаанд хяналт тавих, хуралд бэлтгэх, шийдвэрийн биелэлтийг хангуулах, судалгаа, дүгнэлт гаргах зэрэг үр нөлөө бүхий арга хэлбэрийг ашиглаж ажиллана.

7.12. Энэхүү журмаар зохицуулагдаагүй аливаа асуудлыг тухайн үед ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, хууль эрх зүйн актад нийцүүлэн шийдвэрлэж байна.

----- о О о -----

Журмын нэгдүгээр хавсралт

..... **ОНӨХХК, ОНӨОХК-ийн**  
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**  
**ХУРЛЫН ТОГТООЛ**

20... оны ... дугаар  
сарын ...-ний өдөр

Дугаар .....

.....  
.....тухай

...

..... үндэслэн  
“.....” **ОНӨХХК, ОНӨОХК** -ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 20...  
оны ... дугаар сарын ...-ний өдрийн хурлаас **ТОГТООХ** нь:

1.

.....  
.....

2.

.....  
.....

...

Төлөөлөн удирдах

*"Баянтээг" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын  
2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн .... дугаар тогтоолын  
"Хавсралт №....*

зөвлөлийн дарга

.....



Журмын хоёрдугаар хавсралт

**“.....” ОНӨХХК, ОНӨОХК-ийн  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

20... оны ... дугаар  
сарын ...-ний өдөр

Дугаар .....

.....

“.....” ОНӨХХК, ОНӨОХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
20... оны ... дугаар сарын ...-ний өдрийн хурлын тэмдэглэлд :

“ХЭЛЭЛЦСЭН нь:

.....

..... тухай

ТЭМДЭГЛЭСЭН нь :

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

.....

...

.....

...

.....

...

.....” гэжээ.

Төлөөлөн удирдах  
зөвлөлийн дарга

.....



Журмын дөрөвдүгээр хавсралт

БАТЛАВ:  
ТӨРӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА  
...../...../  
(гарын үсэг) (нэр)

..... ОНӨХХК, ОНӨОХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар  
хэлэлцэх асуудал

“.....” ОНӨХХК, ОНӨОХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
хурал 20... оны ... дугаар сарын ...-ний өдөр, ..... цагаас, .....  
болно.

Д/д	Хэлэлцэх асуудал	Танилцуулах ажилтан
1		
2		
3		
4		

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
нарийн бичгийн дарга.....



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 06

Баянтээг

Г Компанийн 2017-2021 оны санхүүгийн үйл Г  
ажиллагаанд хийсэн аудитын дүгнэлт,  
тайлан сонсох, хэлэлцэх тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, тооллогын комиссын дүнг үндэслэн “Баянтээг” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Баянтээг” ХК-ийн 2017-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн “Эс Жи Эм Ди Аудит” ХХК-ийн аудитын дүгнэлт, тайланг зөвшөөрсүгэй.
2. Аудитын дүгнэлтэд дурдсан зөрчлийг арилгах, зохих шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлэхийг Төлөөлөн Удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал (Ч.Ганхуяг) нарт тус тус даалгасугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



/Ч.ГҮНСЭНХОРОЛ/